



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: "ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ОРА-2025/21-13-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва
Утас: 70353888 Цахим хаяг: purevlkhagvap@audit.gov.mn
Аудитын менежер Б.Буян-Ундрах
Утас: 70350757 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Аудитор Г.Даваасүрэн
Утас: 70350757 Цахим хаяг: davaasureng@audit.gov.mn
Аудитор Б.Азжаргал
Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Орхон аймаг
2025 он



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 12 өдөр

Дугаар A/09

Эрдэнэт

**Аудитын тайлан баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" A/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайлан /ОРА-2025/21-13-ШТА-НА/-г баталгаажуулсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2025 оны 12 сарын 01-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр), аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Б.Ганзориг), Баян-өндөр сумын тамгын газрын дарга (Ш.Өлзийбаяр), Худалдан авах газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Оюунбаяр) нарт зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Баян-өндөр сумын Засаг дарга, аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Буян-Ундрах), аудитор (Г.Даваасүрэн), аудитор (Б.Азжаргал) нарт даалгасугай.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

ТОВЬЁГ

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товьёг	3
График товьёг	4
Зураг товьёг	4
1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:	7
БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.	8
БҮЛЭГ 3. ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ БОЛОВЧ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАРЫН ХҮРЭЭНД ХЭМНЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.	16
ДҮГНЭЛТ:	20
ЗӨВЛӨМЖ:	20
Холбогдох байгууллагын санал:	21

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ЭДЦС	Эрдэнэтийн дулааны цахилгаан станц
ЭБЦДС	Эрдэнэт Булганы цахилгаан дамжуулах сүлжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ДТС	Дулаан түгээх сүлжээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗСБҮА	Зөвлөх сонгох бага үнийн арга
ОНОХА	Олон нийтийн оролцоог хангах арга
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8-12 дугаар зүйлд хамаарах хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалтын зөрчлүүд	9
Хүснэгт 2	Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмын зөрчлүүд	10
Хүснэгт 3	Хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийн жагсаалт	13
Хүснэгт 4	Орон нутагт бүртгэлтэй боловч хувийн хэвшилд ашиглах ТАХ	13
Хүснэгт 5	Орон нутгийн хөрөнгөөр хувийн хэвшилд ашиглах ТАХ	14
Хүснэгт 6	Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд илрүүлсэн зөрчил	16
Хүснэгт 7	Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд илрүүлсэн зөрчил	16
Хүснэгт 8	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн зардлын харьцуулалт	18

График товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
---	---------	-----------------

График 1	Авто тээврийн хэрэгслийн дугаарыг ялгарах тод өнгөөр сольсон байдал	9
График 2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн зөрчил	19

Зураг товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	ЭДЦС ТӨХК, ЭБЦТС ТӨХК-ний дэд захирлуудыг чөлөөлсөн байдал	8
Зураг 2	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог баталсан тушаал-1	11
Зураг 3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог баталсан тушаал-2	11
Зураг 4	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог баталсан тушаал	12

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудитыг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу.
- Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу.
- Засгийн газар болон төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу.

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 санхүүгийн нэгдсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан, төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч тэдгээрийн харьяа байгууллагууд, орон нутгийн өмчит болон ТӨХК-ын 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

**Аудитын
явцад учирсан
хүндрэл,
бэрхшээлүүд:**

- Монгол Улсын 2022, 2023, 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
- Засгийн газрын тогтоолууд
- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”;
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журам”;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолууд,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Даваасүрэн, Б.Азжаргал нар 2024 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 2024 оны 05 дугаар сарын 12-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны дөрөвдүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж, төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихаар хуульчилсан.

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь 2022 онд 4 бүлэг 22 зүйл заалттай батлагдаж, Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2022 онд 1 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт орсон байна.

Орхон аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар нийт 123 байгууллага байгаагаас Төсвийн шууд захирагч 103, Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж 7, Төрийн өмчит аж ахуйн нэгж 5, Өрхийн эрүүл мэндийн төв 8 байна.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын санхүү, нийцлийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2022 онд 9,689.2 сая төгрөг, 2023 онд 1,644.4 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна.

Орхон аймгийн 2024 оны төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 17/04 тогтоолоор баталж, 2024 онд 1 удаа тодотгон өөрчлөн баталжээ.

Орхон аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 177,477.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 712 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулж, 166,681.4 сая төгрөгийн дүнтэй гэрээ байгуулж, 10,796.1 сая төгрөгийг хэмнэж, хөтөлбөр арга хэмжээний биелэлт 93.9 хувьтай хэрэгжсэн байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

1.1 Хуулийн 5, 6, 8, 9, 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Хуулийн 5 дугаар зүйлийн хүрээнд Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн Б/15 дугаар захирамжаар Засаг даргын Хот байгуулал, дэд бүтцийн хөгжлийн асуудал хариуцсан орлогчийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, 2 орлогчтой байсныг 1 орлогчтой болгон өөрчилсөн байна.

Гэсэн хэдий ч Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Б/39 дугаартай захирамжаар “Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах төсөл”-ийн менежерээр Б.О-г орлогч даргын чиг үүргээр томилсон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д “Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.” гэснийг хэрэгжүүлээгүй байх тул зөвлөмж өгөхөөр болов.

“Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК болон “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1¹-д зааснаар дэд захирлуудын орон тоог хасаж, ажлаас чөлөөлсөн байна.

ЭДЦС ТӨХК, ЭБЦТС ТӨХК-ний дэд захирлуудыг чөлөөлсөн байдал

Зураг №1



Дээрх 2 төрийн өмчит компанийн 2024 оны бүтэц орон орон тоонд тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоог батлаагүй байна.


¹ “Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно..”

Аудитаар хуулийн 6.4² дэх заалтын хэрэгжилтийг шалгахад Төрийн болон орон нутгийн өмчид 1007 ширхэг авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаагаас ялгарах тод өнгө бүхий улсын дугааргүй 136 тээврийн хэрэгсэл байна.

Үүнийг графикаар харуулбал:

Авто тээврийн хэрэгслийн дугаарыг ялгарах тод өнгөөр сольсон байдал

График № 1



Орон нутгийн өмчийн газарт актлах санал хүргүүлсэн, замын хөдөлгөөнд оролцдоггүй, мөн бусад төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хооронд шилжүүлэх шалтгаантай 136 авто тээврийн хэрэгслийн улсын дугаарыг солиогүй байна.

Төсвийн шууд захирагч нарын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар хуулийн 8-12 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчлүүд илэрсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8-12 дугаар зүйлд хамаарах хангамж, зарим үйл ажиллагаанд тавих хязгаарлалтын зөрчлүүд

Хүснэгт №1

/мянган төгрөг/

№	Хуулийн зүйл	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хуулийн 8 дугаар зүйл	-	-	1	434.0	-	-	1	434.0
2	Хуулийн 9 дугаар зүйл	-	-	-	-	1	1,760.0	1	1,760.0
3	Хуулийн 12 дугаар зүйл	-	-	-	-	1	1,800.0	1	1,800.0

² Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

- Хуулийн 8.1³-д заасныг зөрчин Орхон аймгийн 27-р цэцэрлэгийн багш нарт байгууллагын төсвөөс 434.0 мянган төгрөгөөр цамц худалдан авсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- Хуулийн 9 дүгээр зүйл 9.3⁴-д заасныг зөрчин Зэвсэгт хүчний ... дугаар анги нь албан хаагчдыг томилолтоор улс орон нутгийн бүтээн байгуулалтад ажилласан хугацаанд томилолтын зардал 1,760.0 мянган төгрөг тооцон олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Хуулийн 12 дүгээр зүйл 12.1.4⁵-д заасныг зөрчин Боловсролын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн Б/32 дугаар тушаалаар 2022, 2023 оны байгууллагын шилдэг 4 ажилтанд тус бүр 500.0 мянган төгрөг нийт 1,800.0 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт тус тус тогтоосон байна.

1.2 Батлагдсан орон тоог хэтрүүлж, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалд төрийн үйлчилгээний ангиллаар гэрээт албан хаагчийг ажиллуулж, төрийн захиргааны шийдвэрийг гаргадаг байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчимд нийцээгүй 39,122.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчмын зөрчлүүд

Хүснэгт №2

№	Хуулийн зүйл	Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Нийт	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хуулийн 4.1 заалт	-	-	-	-	2	5,510.0	2	5,510.0
2	Хуулийн 4.2 заалт	1	-	2	33,612.0	-	-	3	33,612.0
Дүн		1	-	2	33,612.0	2	5,510.0	5	39,122.0

/мянган төгрөг/

- Орхон аймгийн Политехникийн коллеж тайлант оны 05 дугаар сард веб сайт хийлгэхээр “Эго софт” ХХК-тай гэрээ байгуулан 5,000.0 мянган төгрөгийн төлбөрийг 100 хувь шилжүүлсэн боловч одоог хүртэл тухайн хөрөнгийг хүлээж аваагүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн худалдан авах ажиллагааны 2 мэргэжилтнийг нэг төрлийн сургалтад 2 удаа хамруулж, 510.0 мянган төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар нь ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал 19,412.0 мянган төгрөгийг ариутгал халдваргүйжүүлэлт хийх тусгай эрхгүй оёдлын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

³ Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.

⁴ Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

⁵ хуулиар зөвшөөрөөгүй бусад

хязгаарыг тогтоох тухай" тогтоол⁶-ийг зөрчсөн байна. Тухайн зөрчилд 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог Засгийн газрын 2018 оны "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 267 дугаар тогтоол⁷, аймгийн Засаг даргын 2019 оны Бүтэц орон тоог батлах тухай А/701 дугаартай захирамжаар нийт 23 орон тоотой байхаар баталсан байна.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 01 сарын 02-ны өдрийн А/02 дугаартай Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тоо батлах тухай тушаалд Төрийн захиргааны албан хаагчдын бүтэц орон тоог 23, төрийн улс төрийн болон төрийн үйлчилгээний ажилтнуудын бүтэц орон тоог 29, засаг захиргааны анхан шатны нэгжийн бүтэц орон тоог 78 байхаар хавсралтаар баталсан байна.

Зураг -4 Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог баталсан тушаал

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог батлах тушаал		Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог батлах тушаал	
№	Албан тушаал	Ажлын хэргийн бүтэц	Ажлын хэргийн бүтэц
1	Сумын Засаг дарга	1	1
2	Засаг даргын орлогч	1	1
3	Сумын Багш	1	1
4	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
5	Баталгааны ажилтан	1	1
6	Засаг даргын орлогч	1	1
7	Сумын Багш	1	1
8	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
9	Баталгааны ажилтан	1	1
10	Засаг даргын орлогч	1	1
11	Сумын Багш	1	1
12	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
13	Баталгааны ажилтан	1	1
14	Засаг даргын орлогч	1	1
15	Сумын Багш	1	1
16	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
17	Баталгааны ажилтан	1	1
18	Засаг даргын орлогч	1	1
19	Сумын Багш	1	1
20	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
21	Баталгааны ажилтан	1	1
22	Засаг даргын орлогч	1	1
23	Сумын Багш	1	1
24	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
25	Баталгааны ажилтан	1	1
26	Засаг даргын орлогч	1	1
27	Сумын Багш	1	1
28	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
29	Баталгааны ажилтан	1	1
30	Засаг даргын орлогч	1	1
31	Сумын Багш	1	1
32	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
33	Баталгааны ажилтан	1	1
34	Засаг даргын орлогч	1	1
35	Сумын Багш	1	1
36	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
37	Баталгааны ажилтан	1	1
38	Засаг даргын орлогч	1	1
39	Сумын Багш	1	1
40	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
41	Баталгааны ажилтан	1	1
42	Засаг даргын орлогч	1	1
43	Сумын Багш	1	1
44	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
45	Баталгааны ажилтан	1	1
46	Засаг даргын орлогч	1	1
47	Сумын Багш	1	1
48	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
49	Баталгааны ажилтан	1	1
50	Засаг даргын орлогч	1	1
51	Сумын Багш	1	1
52	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
53	Баталгааны ажилтан	1	1
54	Засаг даргын орлогч	1	1
55	Сумын Багш	1	1
56	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
57	Баталгааны ажилтан	1	1
58	Засаг даргын орлогч	1	1
59	Сумын Багш	1	1
60	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
61	Баталгааны ажилтан	1	1
62	Засаг даргын орлогч	1	1
63	Сумын Багш	1	1
64	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
65	Баталгааны ажилтан	1	1
66	Засаг даргын орлогч	1	1
67	Сумын Багш	1	1
68	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
69	Баталгааны ажилтан	1	1
70	Засаг даргын орлогч	1	1
71	Сумын Багш	1	1
72	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
73	Баталгааны ажилтан	1	1
74	Засаг даргын орлогч	1	1
75	Сумын Багш	1	1
76	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
77	Баталгааны ажилтан	1	1
78	Засаг даргын орлогч	1	1
79	Сумын Багш	1	1
80	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
81	Баталгааны ажилтан	1	1
82	Засаг даргын орлогч	1	1
83	Сумын Багш	1	1
84	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
85	Баталгааны ажилтан	1	1
86	Засаг даргын орлогч	1	1
87	Сумын Багш	1	1
88	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
89	Баталгааны ажилтан	1	1
90	Засаг даргын орлогч	1	1
91	Сумын Багш	1	1
92	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
93	Баталгааны ажилтан	1	1
94	Засаг даргын орлогч	1	1
95	Сумын Багш	1	1
96	Мэдээлэл технологийн ажилтан	1	1
97	Баталгааны ажилтан	1	1
98	Засаг даргын орлогч	1	1
99	Сумын Багш	1	1
100	Мэдээлэл технологийн ажилтан	1	1

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог 130 албан хаагчтай байхаар баталснаас гадна багийн хэсгийн ахлагч нэртэй гэрээт 130 ажилчдын цалингийн зардлын төсвийг Иргэдийн Төлөөлөгчийн хурлаар жил бүр батлуулан, 2024 онд 1,333,577.7 мянган төгрөг зарцуулсан байна. Эдгээр гэрээт ажилчдын хууль эрх зүйн орчин,баримтлах бодлого,зарим ажилчдынх нь ажил үүргийн хуваарь тодорхойгүй байна.

⁶ "Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээгээс хамааруулан Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газрыг 57 хүртэл, Булган, Говь-Алтай, Дундговь, Өмнөговь, Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрыг 55 хүртэл, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрыг 41 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай."

⁷ "1. Хүн амын тоо, газар нутгийн хэмжээ, үйлчлэх өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоог харгалзан сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг 1500 хүртэл хүн амтай суманд 13, 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18, 10001-20000 хүртэл хүн амтай суманд 21, 20001-ээс дээш хүн амтай суманд 23 байхаар тус тус тогтоосугай."

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.2-т "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;" гэснийг хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж өгөхөөр болов.

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар хуулийн 15.1.3⁸, 15.1.5⁹, 15.1.6¹⁰-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нийт 431,926.6 мянган төгрөгийн 78 зөрчилд дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Хуулийн хэмнэлтийн бусад арга хэмжээг хэрэгжүүлээгүй зөрчлийн жагсаалт
Хүснэгт №3 /мянган төгрөг/

№	Хуулийн заалт	2024 он							
		Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Нийт зөрчил	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хуулийн 15.1.3 дэх заалт	4	105,322.6	60	286,362.4	12	28,382.6	76	420,067.6
2	Хуулийн 15.1.5 дэх заалт			1	10,844.0	1	1,015.0	2	11,859.0
3	Хуулийн 15.1.6 дэх заалт			3	58,766.4				
	Нийт	4	105,322.6	64	355,972.8	13	29,397.6	78	431,926.6

- Хуулийн 15.1.3-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй 105,322.6 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өгч, 286,362.4 мянган төгрөгийн 60 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 28,382.9 мянган төгрөгийн 12 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Хуулийн 15.1.5-д заасныг хэрэгжүүлээгүй 10,844.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,015.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.
- Хуулийн 15.1.6-д заасныг хэрэгжүүлээгүй 58,766.4 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

2.1 Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

"Улс болон орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" гүйцэтгэлийн аудитаар Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Хуулийн 13.3.2¹¹-д заасныг зөрчин улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар 5,303,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

⁸ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох.

⁹ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах

¹⁰ нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх.

¹¹ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

Орон нутагт бүртгэлтэй боловч хувийн хэвшилд ашиглах ТАХ

Хүснэгт №4

/мянган төгрөг/

№	Хуулийн дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Гүйцэтгэлээр санхүүжилт
1	XVIII.3.27	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Орхон/	820,000.0	720,940.6
2	XVIII.3.6	"Шинэ хөдөө-Тогтвортой хөгжил" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500,000.0	441,354.0
3	XVIII.3.7	"Шинэ хөдөө-хүлэмж" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500,000.0	492,500.0
4	XVIII.3.8	"Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх" төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/	500,000.0	467,406.6
5	XVIII.3.9	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	2,200,000.0	2,200,000.0
6	III.2.3.1	Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/	783,000.0	646,326.10
Нийт			5,303,000.0	4,968,527.3

ХХААХҮС, Эдийн засгийн хөгжлийн сайдын багцаас эрх шилжсэн дээрх 6 төсөл арга хэмжээний хүрээнд нийт 4,968,527.3 мянган төгрөгөөр 2,403 ширхэг тоног төхөөрөмж бий болсноос төрийн байгууллагын хэрэгцээнд 658,600.0 мянган төгрөгийн 104 ширхэг тоног төхөөрөмж ашиглагдаж байна.

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ 3,350,100.0 мянган төгрөгийн 2,173 ширхэг тоног төхөөрөмж, ХХААГ 959,900.0 мянган төгрөгийн 126 ширхэг тоног төхөөрөмжийг ашиглуулах гэрээгээр иргэн аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн байна.

- Хуулийн 13.3.2¹²-д заасныг зөрчин орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар 392,603.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан тайлант онд 170,625.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн хөрөнгөөр хувийн хэвшилд ашиглах ТАХ

Хүснэгт № 5

/мянган төгрөг/

№	Дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Гүйцэтгэлээр санхүүжилт
1	1.1.2	БОАЖГ-ын контор, орон сууцны инженерийн шугам сүлжээний ажил	212,603.10	91,645.0
2	2.3.31	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах	100,000.0	0.0
3	2.3.32	Уурхайчин баг. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах	80,000.0	78,980.0
Нийт			392,603.1	170,625.0

- Хуулийн 13.3.3¹³-д заасныг зөрчин орон нутгийн 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих "Эрдэнэтэд үйлдвэрлэв" барилга барих төсөл арга хэмжээг нийт

¹² хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ

¹³ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

3,582,982.60 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тайланд онд 2,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгох барилгын ажлыг төлөвлөсөн байна.

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн хуулийн 13 дугаар зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Орхон аймгийн хот тохижуулах газар нь хуулийн 13.1.1¹⁴-д заасныг зөрчин худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний дотор дуусгах арга хэмжээ хэрэгжүүлээгүй зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.
- Орхон аймгийн хот тохижуулах газар нь хуулийн 13.1.3¹⁵-д заасныг зөрчин цас хайлуулах бодис худалдан авах ажиллагааны үр дүнд үүссэн 40,000.0 мянган төгрөгийн хэмнэлтээр адил төрлийн бодис худалдан авч нөөцөлсөн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

2.2 Төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд худалдан авах ажиллагааны газарт цахим дэлгүүрт худалдан авах бараа материалын жагсаалтыг хүргүүлээгүйгээс хуулийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдаагүй байна.

2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн хуулийн 14.4¹⁶-д зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- Сэлэнгэ голын сав газрын захиргаа нь 6,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй,
- Орхон аймгийн 24 дүгээр цэцэрлэг нь 3,299.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй,
- Орхон аймгийн 17 дугаар цэцэрлэг нь 2,860.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,078,900 төгрөгийн тавилга эд хогшил, нийт 4,938.9 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй,
- Орхон аймгийн 15 дугаар цэцэрлэг нь 2,288.0 мянга төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй,
- Орхон аймгийн Жаргалант сумын Соёл мэдээллийн төв нь тайлант онд 3,093.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй байна.

Цахим дэлгүүрээс бараа материал худалдан авалт хийдэггүй дараах зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Орхон аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн зарцуулалтын тайлангаар багаж, техник, хэрэгсэл зардлаас 424,615.5 мянган төгрөг, тавилга, эд хогшлын зардлаас 140,524.6 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс хийгээгүй байна.

¹⁴ Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

¹⁵ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх

¹⁶ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно

- “Эрдэнэт ус, ДТС” ОНӨХК нь 2024 онд 2,648,530.0 мянган төгрөгийн худалдан авалтын 98 хувийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.
- “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь 2024 онд 8,095,396.2 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.

Аудитад хамрагдсан хуулийн этгээдүүд тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Төрийн хэмнэлтийн хуулийн 14.1¹⁷-д заасны дагуу Орхон аймгийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлдэггүй зөрчилүүд байна.

Иймд цахим дэлгүүрт бараа ажил үйлчилгээ худалдан авах жагсаалтыг хүлээн авах ажлыг хангалттай зохион байгуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛДЭГ БОЛОВЧ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ НАРЫН ХҮРЭЭНД ХЭМНЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

3.1 Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хуулийн хэрэгжилттэй холбоотой хяналт хэрэгжүүлсэн байна.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас орон нутгийн төрийн байгууллага, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэхдээ Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг хангасан эсэхэд давхар хяналт хийсэн байна.

Санхүүгийн дотоод аудитаар 2023 онд хяналт хийсэн байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийт 138,338.0 мянган төгрөгийн 10 зөрчил илрүүлж, 64,856.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж, 59,653.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 13,829.0 мянган төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Эдгээр зөрчлүүдийг хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд илрүүлсэн зөрчил

Хүснэгт № 6

/мянган төгрөг/

№	Хуулийн заалт	2023 он							
		Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Нийт зөрчил	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хуулийн 4.1 дэх заалт	-	-	-	-	1	5,716.00	1	5,716.00
2	Хуулийн 4.2 дэх заалт	-	-	1	59,653.00	2	1,994.90	3	61,647.90
3	Хуулийн 15.1 дэх заалт	1	60,000.00	-	-	-	-	1	60,000.00
4	Хуулийн 15.2 дэх заалт	1	4,856.00	-	-	4	6,118.10	5	10,974.10

¹⁷ "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ."

		2	64,856.00	1	59,653.00	7	13,829.00	10	138,338.00
--	--	---	-----------	---	-----------	---	-----------	----	------------

Санхүүгийн дотоод аудитаар 2024 онд хяналт хийсэн байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд нийт 90,711.7 мянган төгрөгийн 16 зөрчил илрүүлж 64,271.1 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага, 26,440.6 мянган төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Эдгээр зөрчлүүдийг хүснэгтээр харуулбал:

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас 2024 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд илрүүлсэн зөрчил

Хүснэгт № 7

/мянган төгрөг/

№	Хуулийн заалт	2024 он							
		Зөвлөмж		Албан шаардлага		Төлбөрийн акт		Нийт зөрчил	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хуулийн 4.1 дэх заалт	-	-	1	1,064.20	3	19,808.70	4	20,872.90
2	Хуулийн 4.2 дэх заалт	-	-	-	-	3	1,472.00	3	1,472.00
3	Хуулийн 15.1 дэх заалт	-	-	8	63,206.90		2,409.30	8	65,616.20
4	Хуулийн 15.2 дэх заалт	-	-	-	-	1	2,750.60	1	2,750.60
	Нийт	0.0	0.0	9	64,271.10	7	26,440.60	16	90,711.70

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу илрүүлсэн зөрчил нь 2023 онд нийт 8 төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг хамарсан, 2024 онд 12 төсвийн байгууллага, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг хамарсан байна.

Төрийн Аудитын байгууллагаас 2024 онд төсвийн ерөнхийлөн захирагч 1, төсвийн төвлөрүүлэн захирагч 2, Засгийн газрын тусгай сан 2, орон нутгийн тусгай сан 8, төсвийн шууд захирагч 112, төсөл хөтөлбөр 1, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 12 нийт 138 хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн аудит хийж, 81 байгууллагын удирдах албан тушаалтан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19.2¹⁸-т заасан хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 924,507.9 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлэн, аудитын шийдвэрийг хүргүүлсэн.

3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулж, зарим заалтыг хүчингүй болгосноор төсвийн зардал өссөн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Засгийн газрын урсгал шилжүүлгийг хассан дүнгээр 2023 оны зардлын гүйцэтгэлийг 2024 оны зардлын гүйцэтгэлтэй харьцуулахад 66.8 тэрбум төгрөг буюу 61.9 хувиар өссөн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023, 2024 оны төсвийн гүйцэтгэлийн зардлын харьцуулалт

Хүснэгт № 8

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2023 он	2024 он	Зөрүү	Хувь
---	----------	---------	---------	-------	------

¹⁸ Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ.

1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, нийгмийн даатгалын шимтгэл	16,986,001.6	30,357,977.4	13,371,975.84	78.7
2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,275,737.1	5,506,628.0	1,230,890.89	28.8
3	Хангамж, бараа материалын зардал	2,447,307.9	3,128,311.4	681,003.49	27.8
4	Нормативт зардал	164,732.8	212,393.2	47,660.36	28.9
5	Эд хогшил, урсгал засварын зардал	2,264,993.5	3,701,472.3	1,436,478.82	63.4
6	Томилолт, зочны зардал	190,885.0	308,667.6	117,782.63	61.7
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,671,869.6	24,935,157.2	6,263,287.61	33.5
8	Бараа үйлчилгээний бусад зардал	1,221,281.4	1,575,574.6	354,293.22	29.0
9	Хөрөнгийн зардал	59,646,159.7	101,704,575.7	42,058,415.92	70.5
10	Хувийн хэвшлийн байгууллагад олгосон татаас	1,217,712.2	1,452,636.8	234,924.6	19.3
11	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	130,670.8	123,668.5	(7,002.3)	-5.4
12	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,098.6	112,138.4	106,039.8	17.4
13	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	142,603.3	109,193.0	(33,410.3)	-23.4
14	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	371,823.8	371,823.8	100
15	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	386,915.8	590,785.2	203,869.4	52.7
16	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	294,160.1	749,740.8	455,580.7	154.8
	Нийт дүн	108,047,129.4	174,940,743.9	66,893,614.5	61.9

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын өсөлт нь гэрэл цахилгааны үнэ 465,221.2 мянган төгрөг буюу 47.2 хувиар нэмэгдсэн, түлш халаалт 469,189.2 мянган төгрөг буюу 20.8 хувиар өссөн, цэвэр бохир ус 314,035.9 мянган төгрөг буюу 36.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.
- Эд хогшил, урсгал засварын зардлын өсөлт нь багаж, техник, хэрэгсэл зардал 97,487.1 мянган төгрөг буюу 29.8 хувиар өссөн, тавилга 62,630.2 мянган төгрөг буюу 80.4 хувиар өссөн, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 70,400.2 мянган төгрөг буюу 74.8 хувиар өссөн, урсгал зардал 1,205,961.3 мянган төгрөг буюу 68.2 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 9,050,685.9 мянган төгрөг буюу 58.5 хувиар өссөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд 3 удаа тус тус нэмэлт өөрчлөлт орж, зарим заалтыг хүчингүй болгосонтой холбоотой зарим зардал өсжээ. Үүнд:

- Хуулийн 12.1.2¹⁹ дэх заалт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонтой холбоотой 371,823.8 мянган төгрөгийн ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлтийн зардал орон нутгийн төсвийн хөрөнгөөс олгосон.
- Хуулийн 15.2.3²⁰ заалт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонтой холбоотой Томилолт, зочны зардал 117,782.6 мянган төгрөгөөр, Хангамж,

¹⁹ ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал

²⁰ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх

бараа материалын зардал 681,003.5 мянган төгрөгөөр, хоол, хүнсний зардал 24,955.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

3.3 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилт 89.8 хувьтай байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар 112 төсвийн шууд захирагч, 2 төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит 12 аж ахуйн нэгжийн шилэн дансны үйл ажиллагаанд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудит хийлээ. Аудитаар 45 төсөв захирагчийн Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Аудитаар алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 13 албан шаардлага, 32 зөвлөмж хүргүүлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн зөрчил

График № 2



1. 5,849.9 мянган төгрөгийн 32 зөрчилд зөвлөмж
2. 13 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн дагуу 2023 оны санхүү тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийг хангаагүй 7 байгууллагад өмнөх оны аудитын шийдвэр хэрэгжүүлээгүй зөрчилд 7 албан шаардлага хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²¹-д заасны дагуу Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүүгийн хөгжлийн хороо нь Санхүүгийн хяналт, аудитын албаны аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2023 оны 4 дүгээр улирал, 2024 оны 1 дүгээр улирлын байдлаар шалгасан дүнг хэлэлцсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйл "Тайлагналын ил тод байдлын хэрэгжилт"-ийг төрийн өмчийн 4 байгууллага, орон нутгийн өмчит 7 байгууллагад хуулийн заалт бүрээр буюу нийт 14 үзүүлэлтээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй мэдээлсэн эсэхийг тулган шалгахад мэдээллийг иж бүрэн үнэн зөв байршуулдаггүй байна.

²¹ Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

ДҮГНЭЛТ:

- 1.1 Хуулийн 5, 6, 8, 9, 12 дугаар зүйлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.
- 1.2 Батлагдсан орон тоог хэтрүүлж, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалд төрийн үйлчилгээний ангиллаар гэрээт албан хаагчийг ажиллуулж, төрийн захиргааны шийдвэрийг гаргаж байна.
- 2.1 Хуулийн 13 дугаар зүйлийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.
- 2.2 Төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд худалдан авах ажиллагааны газарт цахим дэлгүүрт худалдан авах бараа материалын жагсаалтыг хүргүүлээгүйгээс хуулийн 14 дүгээр зүйлийн хэрэгжилт хангагдаагүй байна.
- 3.1 Орхон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд хуулийн хэрэгжилттэй холбоотой хяналт хэрэгжүүлсэн байна.
- 3.2 Төрийн хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулж, зарим заалтыг хүчингүй болгосноор төсвийн зардал өссөн байна.
- 3.3 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилт 89.8 хувьтай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аймгийн Засаг даргад:

- Орлогчийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгохгүй байх.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт:

- Төрийн захиргааны ангилалын албан тушаалд Төрийн үйлчилгээний ангиллаар гэрээт ажилтан ажиллуулахгүй байх.

Баян-Өндөр Сумын Засаг даргын Тамгын газарт:

- Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газрын бүтэц, орон тоог Засгийн газраас тогтоосон хязгаарт багтаах,
- Төрийн захиргааны ангилалын албан тушаалд Төрийн үйлчилгээний ангиллаар гэрээт ажилтан ажиллуулахгүй байх.
- Багийн хэсгийн ахлагч нэртэй гэрээт 130 ажилчдын холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

- Төсвийн шууд захирагч нараас хуулийн дагуу худалдан авахаар төлөвлөсөн 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг гаргуулан авч цахим дэлгүүрт байршуулах ажлыг зохион байгуулах.